



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
АХИСАН ТҮВШНИЙ СУРГУУЛЬ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их сургуулийн гудамж 1, Утас: 7730-7730 /4501, 4502/
И-мэйл: graduate@num.edu.mn
Вэб сайт: https://gradschool.num.edu.mn

2021.11.30 № 12/44
танай _____ -ны № _____ -т

Г Бүтээлийн хуулбарлалтыг шалгах тухай

Тус сургууль нь МУИС-ийн захирлын 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/56 дугаар тушаалаар батлагдсан “Магистр, докторын судалгааны ажлын үр дүнг хүлээлгэн өгөх журам”-ын 5-р бүлэг дэх заалтуудад үндэслэн 2020-2021 оны хичээлийн жилийн хаврын улирлаас эхлэн “Бүтээлийн хулгайгаас сэргийлэх систем”-ийг хэрэглээнд нэвтрүүлж магистрын судалгааны ажил, докторын диссертацийг шалгах ажлыг эхлүүлсэн.

Цаашид энэхүү системийг улам боловсронгуй болгож хөгжүүлэх тал дээр Ахисан түвшний сургуулиас анхаарч ажиллаж байгаа тул магистрант, докторантууд болон удирдагч багш нар “Магистр, докторын судалгааны ажлын үр дүнг хүлээлгэн өгөх журам”-ыг баримталж ажиллана уу.

Дээрх журмын 5-р бүлэг дэх заалтын хувьд дараах өөрчлөлттэй байгааг энэ хичээлийн жилд дипломын хамгаалалтад орж буй магистрант, докторант нар анхаарна уу. Үүнд:

1. Магистрант, докторант нь эцсийн байдлаар боловсруулсан судалгааны ажлын бичвэрээ удирдагч багшийн хамт “Бүтээлийн хулгайгаас сэргийлэх систем” (<http://pds.num.edu.mn>)-ээр шалгуулж, 1-р хавсралт дахь “Баталгааны хуудас”-ыг бөглөн гарын үсгээр баталгаажуулж, удирдагч багшийн албан цахим хаягаас **Ахисан түвшний сургуульд** grad.research@num.edu.mn (Cc: суралцагчийн и-мэйл) хаягаар ирүүлнэ.
2. Баталгааны хуудсыг ирүүлэх сүүлийн хугацаа:
 - Магистрант: Жинхэнэ хамгаалалт болохоос **ажлын 3 хоногийн өмнө**
 - Докторант: Жинхэнэ хамгаалалт болохоос **20 хоногийн өмнө**
3. Баталгааны хуудсыг үндэслэн жинхэнэ хамгаалалтаас өмнө магистрын ажил хамгаалуулах зөвлөл болон докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд Ахисан түвшний сургуулиас тодорхойлох бичиг илгээнэ.

Баталгааны хуудас нь Зохиогчийн эрхийн нотолгоо бүхий баримт болох бөгөөд бүтээлийн хуулбарлалтыг шалгаж ирүүлээгүй суралцагчийн асуудлыг журмын 5.4-т заасны дагуу шийдвэрлэнэ.

Хавсралт хуудастай.

1. Баталгааны хуудас
2. Бүтээлийн хуулбар шалгах заавар:

Жич: Систем нь зөвхөн МУИС-ийн багш, ажилтны Сиси эрхээр нэвтэрнэ.

ЗАХИРАЛ



МАГИСТРАНТ, ДОКТОРАНТУУД,
БОЛОН УДИРДАГЧ БАГШ НАРТ

Н.БААТАРБИЛЭГ

3341202120